MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Canada

Бодлогын товч танилцуулгыг үр дүнтэй боловсруулах арга

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

MERIT төслийн зөвлөх, Мишэл Филион

2021 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Агуулга

Танилцуулга: олон нийтэд чиглэсэн мэдээлэл харилцаа

Танилцуулга: хүн хоорондын харилцаа

Харилцааны арга техник

Сэтгэл хөдлөлийг анхаарч үзэх нь

Бүтэц

Жендэрийн дүн шинжилгээний стандарт агуулга

Бодлогын товч танилцуулга

Бодлогын товч танилцуулга нь тухайн асуудлын хүрээнд зохих шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэл юм.

Бодлогын товч танилцуулга дараах үр дүнд чиглэнэ:

Шийдвэр гаргах эрх бүхий албан хаагч уг баримт бичигтэй танилцсаны дараа зохих шийдэл, арга хэмжээний чиглэлийг тодорхойлох хангалттай мэдээлэл (үндэслэл, баримт нотолгоо, ижил асуудлыг шийдвэрлэсэн өмнөх жишиг гэх мэт) авсан байна.

Олон нийтэд чиглэсэн мэдээлэл харилцаа

Олон нийтэд чиглэсэн мэдээлэл харилцаа нь хувь хүн эсвэл хэсэг хүмүүс хамтран тодорхой сэдвээр мэдээлэл, танилцуулга хийхийг хэлнэ.

Товч танилцуулгыг ганц хүнд зориулан боловсруулж болох ч энэ нь нийтэд түгээгдэж болзошгүй тул олон нийтийн мэдээлэл харилцааны аргын нэг гэж үзэх нь зүйтэй.

Уг баримт бичиг нь хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн тохиолдолд дурдагдсан баримт, мэдээллийн болзошгүй үр дагаврыг тооцоолох, үг хэллэгийн сонголтод няхуур хандах хэрэгтэй.

Хүн хоорондын харилцаа

Хүн хоорондын харилцаа нь хоёр ба түүнээс дээш хүн хоорондын мэдээлэл солилцоог хэлнэ.

Хүмүүс хувийн болон бусад харилцаанд аман, аман бус дохио зангааг хэрхэн ашиглаж зорьсон зорилгодоо хүрч буйг судалдаг ухагдахуун юм.

Өмнө авч үзсэн товч танилцуулга ч мөн адил хүн хоорондын харилцааны нэг хэсэг.

Уг баримт бичиг нь албан хаагчийн, байгууллагын ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой асуудалд нөлөө үзүүлэх тохиолдолд хувь хүний эгод тодорхой байдлаар нөлөөлж байдаг.

Сендвич арга

- Сендвич арга нь шүүмжлэлийг магтаалтай хослуулж хүргэхийг хэлнэ.
- Яриа хэлэлцүүлгийг эерэг санал зөвлөмжөөр эхлүүлсний дараа шүүмж өгч, талархал илэрхийлэн дуусгана.
- Уг арга нь яриа хэлэлцүүлгийг илүү найрсаг уур амьсгалтай өрнүүлэх зорилготой.
- Санал шүүмжлэл авч сурсан хүн аливаа үнэлгээнд илүү нээлттэй ханддаг.



Баримт бичигтэй танилцаж буй хүний сэтгэл хөдлөл

Товч танилцуулга нь дор хаяж 5 төрлийн сөрөг сэтгэл хөдлөл, мэдрэмжийг үүсгэх магадлалтай:

- Өөрийн ажлын үр дүнг дутуу үнэлэн сэтгэл зовних;
- Мэргэжлийн болон хувь хүний түвшинд асуудал тулгарсан мэт санагдаж, эмээх;
- Жендэрийн талаарх өөрийн мэдлэг ойлголтын зөрүүд сэтгэл зовних;
- Тухайн ажлыг ойлгож мэдэх өөрийн чадавхад эргэлзэх;
- Өөрийн санааг илэрхийлэхэд хэт болгоомжлох.

Анхаарах зүйлс

- Бодлогын баримт бичгийг үнэлэхдээ уг бодлогыг боловсруулсан албан хаагч сайн үр дүнд хүрэхийг зорьж боловсруулсан гэдгийг санах.

- Баримт бичигтэй танилцах, тэмдэглэл хөтлөх явцад сөрөг сэтгэл хөтлөлд автахаас зайлсхийх.

- Сэтгэл хөдлөлөөс хандахаас сэргийлж, өөртөө түр завсарлага авч боловсруулж буй танилцуулгаа нягтлах, анхаарах.

- Танилцуулгын сүүлийн хувилбарт хяналтын уншлага хийж, шүүмжлэлийн хурц өнгө аясыг аль болох багасгах.

Анхаарах зүйлс

Хийж болох зүйлс	*Болохгүй зүйлс*
Баримт бичигтэй танилцах хүний хэрэгцээ шаардлагыг асууж, таньж мэдэх. Тавигдах магадлалтай асуултыг урьдчилан бэлдэж, хариулт өгөх.	Хэн нэгнийг тухайн асуудлаар мэргэжлийн түвшний мэдлэг, ойлголттой гэж урьдчилан таамаглахгүй байх.
Хэл зүйн хувьд идэвхтэй хэв дээр, үйл хөдлөл заасан үйл үг ашиглан товч, тодорхой, богино өгүүлбэрээс бүрдсэн баримт бичиг боловсруулах. Нэг догол мөрт нэг санаа агуулах.	Үгийн товчлол, дайвар үг, тэмдэг нэрийг хэтрүүлэн ашиглахгүй байх.
Бодлогын товч танилцуулгын зорилгыг тусгах. Баримт нотолгоонд үндэслэсэн боловсруулах. Тухайн асуудлын хүрээнд шийдэх тодорхой шийдвэр гаргахгүй тохиолдолд гарах үр дагаврыг тооцоолон тусгах.	Дүгнэлт, зөвлөмж хэсэгт ямар нэгэн шинэ мэдээлэл оруулахгүй байх. Хувийн үзэл бодлоо тусгахгүй байх.

Бүтэц

- Хураангуй
- Шийдэх асуудал
- Суурь мэдээлэл
- Үндсэн хэсэг
- Дүгнэлт, зөвлөмж, стратеги, санал болгож буй шийдэл, байр суурь
- Дараагийн алхам

Үндсэн хэсэг: Шалгах хуудас ашиглах!

Шинээр бодлогын төсөл боловсруулан өргөн барьж буй байгууллага дараах зүйлсийг тусгасан эсэх:

- Тухайн салбарын үйл ажиллагааны хүйсээр ангилсан дүн шинжилгээ;
- Тухайн бодлогын хүрээнд жендэрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай тайлбар;
- Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн нөөц бололцоо хангалттай эсэх;
- Жендэрийн асуудлыг шийдэхэд чиглэсэн өмнөх оны төсвийн зарцуулалтын тоо мэдээлэл байгаа тохиолдолд үүнийг тусгах, мөн зарцуулалтыг хэрхэн сайжруулж болох тухай саналыг тусгах;
- Тухайн бодлогын жендэрийн урт хугацааны нөлөөллийг тусгах.

Жендэрийн стандарт агуулга

- Хүйсээр ангилсан тоо мэдээлэл;
- Салбарын жендэрийн дүн шинжилгээ;
- Байгууллагын зүгээс бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах чадавх;
- Нийгэмшлийн нөлөөлөл;
- Нийгэм дэх охид, эмэгтэйчүүдийн байдал;
- Дараагийн алхам: Нарийвчилсан зөвлөмж

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Canada

Mongolia:
Enhancing Resource Management through Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000